



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2021

Э-сонин

05-Р САР

94-р дугаар






Зах зээлийн тойм


/2021.05.31-ний өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр	20
2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/	14,445,186,732.02
Хувьцаа /хоёрдогч/	12,473,410,806
Багцын арилжаа	1,353,949,800
Хөрөнгө оруулалтын сан /хоёрдогч/	1,963,928,558.17
Компанийн бонд /анхдагч/	0.0
Компанийн бонд /хоёрдогч/	7,847,367.85
ХБҮЦ /хоёрдогч/	0.0
3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг	35,201,523
Хувьцаа /хоёрдогч/	28,429,760
Багцын арилжаа	5,005,418
Хөрөнгө орцлалтын сан /хоёрдогч/	6,771,696
Компанийн бонд /анхдагч/	0.0
Компанийн бонд /хоёрдогч/	67
ХБҮЦ /хоёрдогч/	0
4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо	29,973


TOP-20 индекс




MSE B индекс



Зах зээлийн үнэлгээ



MSE A индекс



БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААС

1. Нийт үнэт цаас	185
100% төрийн өмчит	17
Төрийн өмчийн оролцоотой	10
Хувийн өмчийн	158
I ангилал	18
II ангилал	42
III ангилал	125
Компанийн бонд	2
Хөрөнгө оруулалтын сан	1
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	1

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	53
Үүнээс: Брокер, Дилер	53
Андеррайтер	16
Хөрөнгө оруулалтын зөвлөх	14



АРИЛЖААНД ИДЭВХТЭЙ ОРОЛЦСОН ГИШҮҮН ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИУД

/2021.05.31-ний байдлаар/

	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн / авсан, зарсан/ (төг)
		Тоо ширхэг	Үнийн дүн (төг)	Тоо ширхэг	Үнийн дүн (төг)	
1	АРД СЕКЮРИТИЗ ХХК	12,583,669	8,476,821,809	8,986,496	7,333,988,787	15,810,810,596.43
2	БИДИСЕК ХК	2,408,513	1,750,851,309	4,052,088	2,128,255,121	3,879,106,430.65
3	ГОЛОМТ КАПИТАЛ ХХК	6,220,763	1,248,873,985	9,051,134	1,727,458,738	2,976,332,723.00
4	ТИ ДИ БИ КАПИТАЛ ХХК	1,587,973	372,566,741	3,834,963	1,043,661,713	1,416,228,454.13
5	БУМБАТ-АЛТАЙ ХХК	2,014,169	614,953,031	1,516,716	667,981,803	1,282,934,834.49
6	ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК	1,315,191	312,181,692	1,533,861	178,118,907	490,300,599.30
7	ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК	207,449	212,551,710	86,017	207,028,713	419,580,422.75
8	АПЕКС КАПИТАЛ ҮЦК	1,343,883	275,799,947	763,309	142,816,312	418,616,259.36
9	СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ХХК	1,136,923	218,810,285	680,337	169,558,838	388,369,123.19
10	НЭЙШНЛ СЭКЮРИТИС ХХК	503,593	170,369,203	250,403	121,063,636	291,432,838.36
11	МИРЭ ЭССЕТ СЕКЮРИТИС МОНГОЛ ХХК	324,703	93,049,061	2,353,620	158,220,127	251,269,187.82
12	НОВЕЛ ИНВЕСТМЕНТ ХХК	250,588	181,549,798	148,077	67,100,656	248,650,454.29
13	БЛҮМСБЮРИ СЕКЮРИТИЕС ХХК	245,348	89,594,184	197,858	53,961,879	143,556,063.16
14	РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК	2,833,461	141,576,002	250	1,457,900	143,033,902.24
15	МАСДАК ХХК	869,448	35,654,826	5,027	59,050,500	94,705,325.75
16	ГАУЛИ ХХК	104,496	32,178,188	544,577	56,131,876	88,310,064.74
17	МОНГОЛ СЕКЮРИТИЕС ХК	0	0	37,708	73,975,175	73,975,175.00
18	ГҮҮДСЕК ХХК	298,815	36,765,289	173,470	34,609,824	71,375,113.23
19	МОНСЕК ХХК	122,735	32,817,538	92,853	38,248,797	71,066,334.93
20	ЭС ЖИ КАПИТАЛ ХХК	330,000	24,750,000	334,781	25,161,166	49,911,166.00

ИДЭВХТЭЙ АРИЛЖИГДСАН ХУВЬЦАА

/2021.05.31-ний байдлаар/

№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн (төг)	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт %/
1	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	426,478	4,939,191,050.00	12,500.00	10,040.00	-1.97
2	XOC	ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН	6,771,696	1,963,928,557.17	333.67	240.01	-5.83
3	ADB	АРД КРЕДИТ ББСБ	5,209,969	1,544,376,147.22	329.00	240.00	-10.10
4	MMX	МАХИМПЕКС	492,583	1,379,254,850.00	2,900.00	2,688.00	4.13
5	TUM	ТҮМЭН ШУВУУТ	6,252,178	1,327,528,766.69	244.99	208.00	-0.28
6	AIC	АРД ДААТГАЛ	370,025	542,365,749.00	1,519.00	1,301.00	-11.87
7	APU	АПУ	631,492	452,567,926.41	729.99	700.00	-1.75
8	BUN	БУЛГАН УНДРАГА	8,295	441,776,865.00	87,280.00	9,365.00	971.58
9	GOV	ГОВЬ	1,089,353	259,301,959.81	247.99	235.01	-3.74
10	INV	ИНВЕСКОР ББСБ	84,489	248,991,471.00	3,400.00	2,800.00	-11.40
11	LEND	ЛЭНДМН ББСБ	4,640,337	227,771,805.79	52.00	45.00	-8.66
12	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	2,730,282	202,349,656.71	74.90	72.00	-2.35
13	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	68,288	135,154,882.00	2,250.00	1,753.00	2.45
14	BODI	БОДЬ ДААТГАЛ	932,503	119,265,569.22	129.99	116.00	-3.62
15	TTL	ТАВАН ТОЛГОЙ	13,788	94,741,915.00	7,045.00	6,680.00	-0.44
16	MFC	МОНОС ХУНС	1,261,425	85,555,711.40	68.90	66.00	0.00
17	ITLS	АЙТҮҮЛС	808,474	75,992,503.68	108.50	85.00	5.71
18	SUU	СҮҮ	345,715	72,269,394.69	215.00	206.00	-0.25
19	MNP	МОНГОЛ ШУУДАН	43,460	58,125,063.00	1,520.00	1,220.00	-13.44
20	NEH	ДАРХАН НЭХИЙ	1,863,289	45,623,118.16	27.30	19.50	-24.87



ХАНШИЙН ӨСӨЛТТЭЙ ХУВЬЦАА

/2021.05.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (төг)		Ханшийн өөрчлөлт (төг)	Өөрчлөлт /%/
			2021-04-30	2021-05.31		
1	БУЛГАН УНДРАГА	8,295	8,145.00	87,280.00	79,135.00	971.58
2	АВТО ИМПЕКС	40	2,010.00	2,950.00	940.00	46.77
3	СТАНДАРТ АГРИКАЛЧЕР ГРУПП	4,130	125.00	180.00	55.00	44.00
4	СИЛК НЕТ	4	775.00	1,024.00	249.00	32.13
5	БАГАНУУР	6,785	920.17	1,200.00	279.83	30.41
6	ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ	655	131.15	170.00	38.85	29.62
7	МОН-ИТ БУЛИГААР	28	5,865.00	7,300.00	1,435.00	24.47
8	МОНГОЛ ДААТГАЛ	81	2,350.00	2,900.00	550.00	23.40
9	МОНГОЛ ШЕВРО	38	1,480.00	1,800.00	320.00	21.62
10	СОР	121	450.00	517.34	67.34	14.96
11	ДАРХАН ХӨВӨН	1	6,900.00	7,900.00	1,000.00	14.49
12	БУЛГАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	78	460.00	520.00	60.00	13.04
13	МИК ХОЛДИНГ	1	11,600.00	12,800.00	1,200.00	10.34
14	БИ ДИ СЕК	25,580	1,090.00	1,191.00	101.00	9.27
15	МОНГОЛ АЛТ	66	16,500.00	18,000.00	1,500.00	9.09
16	ХАЙ БИ ОЙЛ	45,800	55.04	60.00	4.96	9.01
17	ХӨВСГӨЛ УСАН ЗАМ	35	450.00	478.00	28.00	6.22
18	АЙТҮҮЛС	808,474	93.35	98.68	5.33	5.71
19	ТАНДЭМ ИНВЕСТ ББСБ	61,698	18.19	19.17	0.98	5.39
20	МАХИМПЕКС	492,583	2,689.00	2,800.00	111.00	4.13

ХАНШИЙН БУУРАЛТТАЙ ХУВЬЦАА

/2021.05.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (төг)		Ханшийн өөрчлөлт (төг)	Өөрчлөлт %
			2021-04-30	2021-05.31		
1	ТАВ	1,241	9,000.00	6,750.00	-2,250.00	-25.00
2	ДАРХАН НЭХИЙ	1,863,289	26.62	20.00	-6.62	-24.87
3	МОНГОЛ САВХИ	60	700.00	595.00	-105.00	-15.00
4	УЛААНСАН	186	1,095.00	931.00	-164.00	-14.98
5	ГАН ХИЙЦ	2	15,700.00	13,350.00	-2,350.00	-14.97
6	ШИВЭЭ ОВОО	1,322	1,785.00	1,528.00	-257.00	-14.40
7	ОЛЛОО	17,469	29.50	25.32	-4.18	-14.17
8	МОНГОЛ ШУУДАН	43,460	1,503.00	1,301.00	-202.00	-13.44
9	АРИГ ГАЛ	50	2,873.00	2,500.00	-373.00	-12.98
10	МОННООС	1	2,500.00	2,185.00	-315.00	-12.60
11	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	55	86,960.00	76,050.00	-10,910.00	-12.55
12	АРД ДААТГАЛ	370,025	1,483.00	1,307.00	-176.00	-11.87
13	ИНВЕСКОР ББСБ	84,489	3,386.00	3,000.00	-386.00	-11.40
14	ТҮШИГ УУЛ	10,376	1,000.00	895.00	-105.00	-10.50
15	АРД КРЕДИТ ББСБ	5,209,969	299.44	269.20	-30.24	-10.10



БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛЫН СТАНДАРТЫГ МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД НЭВТРҮҮЛНЭ

Монголын хөрөнгийн бирж (МХБ), Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ), Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо (ТоС Холбоо), НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр (UNEP), Тогтвортой байдлын санхүүгийн төвүүдийн сүлжээ (FC4S), Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК), НҮБ-ын хамтарсан хөтөлбөр тус тус хамтран хэрэгжүүлж буй “Монголын тогтвортой хөрөнгийн биржийн санаачилга” (МТХБС) төслийн хүрээнд “Монголын хөрөнгийн зах зээлд байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын тайлагналын стандартыг нэвтрүүлэх нь” сэдэвт цахим вебинарыг 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдөр зохион байгууллаа.

Вебинарт МХБ-д бүртгэлтэй компаниуд, үнэт цаас гаргахаар төлөвлөж буй байгууллагууд, үнэт цаасны компаниуд, бодлого боловсруулагчид, олон улсын байгууллагууд, санхүүгийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд болон олон нийтийн төлөөлөөс бүрдсэн нийт 200 орчим төлөөлөл оролцож, БОНЗ-ын тайлагналын ач холбогдол, олон улсын чиг хандлага, сайн жишээ, Монгол Улсын хөрөнгийн зах зээлд нэвтрүүлэх стандартын талаар мэдээлэл авлаа.



Арга хэмжээний нээлтийн үеэр СЗХ-ны дэд дарга Н.Хүдэрчулуун “СЗХ тогтвортой санхүүжилтийн асуудлыг анхнаас нь дэмжиж ирсэн бөгөөд цаашид бодлого тодорхойлогчийн хувьд тогтвортой, ногоон санхүүжилтийг дэмжих, тэр дундаа үнэт цаас гаргагчдын байгаль орчин, нийгэм, засаглалын ил тод байдал, тайлагналыг сайжруулах, үүнийг дэмжсэн бодлого, зохицуулалтыг гаргахад хамтран ажиллах тал дээр онцгой ач холбогдлыг өгнө” гэжээ. Түүнчлэн МХБ-ийн Гүйцэтгэх захирал Х.Алтай “Монголын хөрөнгийн бирж нь НҮБ-ын дэргэдэх Тогтвортой хөгжилд чиглэсэн хөрөнгийн биржүүдийн холбоонд 2017 онд элссэнээс хойш хариуцлагатай хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгыг тавин ажиллаж байгаа билээ. Энэхүү зорилгын хүрээнд бид тогтвортой байдалд чиглэсэн тайлагналын стандартыг нэвтрүүлж, зах зээлийн зохицуулагч байгууллагын хувьд үнэт цаас гаргагчид, гишүүн компаниуд болон нийт зах зээлийн оролцогчдыг уриалан, тогтвортой хөгжлийг дэмжсэн зах зээлийг бий болгохын төлөө ажиллах болно” гэв.

ҮЙЛ ЯВДАЛ

Вебинарын үеэр мөн “Тогтвортой хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжихэд хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг”-т МХБ-ийн Гүйцэтгэх захирал Х.Алтай болон ТоС Холбооны Удирдах зөвлөлийн дарга Норихико Като нар гарын үсэг зурлаа.

Уг хамтын ажиллагааны хүрээнд талууд тогтвортой, ногоон хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр үнэт цаас гаргагч компаниудад зориулсан БОНЗ-ын ил тод байдал, тайлагналын журам, стандарт, гарын авлагыг боловсруулахаас гадна, холбогдох талуудын чадавхийг бэхжүүлэх, хариуцлагатай хөрөнгө оруулалт, тогтвортой бизнесийн үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллах юм. “Монгол Улсын банкууд хамтран 2013 оноос хойш Тогтвортой санхүүжилт (ТоС), ногоон зээлийн зарчмуудыг боловсруулан, амжилттай хэрэгжүүлж байна. Гэвч цаашид Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжлийн зорилтуудыг биелүүлэхэд санхүүгийн зах зээлийг бүхэлд нь тогтвортой санхүүжилтэд чиглүүлэх шаардлагатай байгаа тул МХБ, СЗХ болон олон улсын түншүүдтэйгээ энэ чухал зорилгын хүрээнд хамтран ажиллахдаа таатай байна” гэж ТоС Холбооны Удирдах зөвлөлийн дарга Норихико Като онцоллоо.

ЭРДЭНЭ РЕСУРС 2021 ОНЫ 1-Р УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, БАЯН ХӨНДИЙ АЛТНЫ ТӨСЛИЙН ТУХАЙ ТАНИЛЦУУЛЛАА

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь 2021 оны 3 сарын 31-нд дуусгавар болсон нэгдүгээр улирлын санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, Баян Хөндий Алтны Төслийн хөгжүүлэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг олон нийтэд танилцууллаа.

Компани нь 1-р улиралд Баян Хөндий Алтны Төслийн нарийвчилсан загварчлал болон инженерчлэлийн ажлыг эцэслэж боловсруулах үйлдвэрээс бусад дэд бүтцийн холбогдох зөвшөөрлийг авсан байна. Мөн Хар Морь талбайд газрын дөт гүнд өндөр агуулга бүхий алтны эрдэсжилтийг илрүүлсэн байна.



Erdene Resource Development



"ИНВЕСКОР ББСБ" ХК БОНД ГАРГАНА

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн А10 тоот тушаалаар бүртгэгдсэн "Инвескор ББСБ" ХК-ийн 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, хоёр жилийн хугацаатай, жилийн 12-14 хувийн хүүтэй, нийт 20 тэрбум төгрөг хүртлэх үнийн дүн бүхий 200,000 ширхэг өрийн хэрэгслийг Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 200 тоот тогтоолоор бүртгэж нийтэд санал болгон арилжаалахыг зөвшөөрсөн байна.

Тус компани энэхүү бондыг 3 үе шаттайгаар олон нийтэд санал болгон худалдаж, 20.0 тэрбум төгрөг хүртэлх санхүүжилтийг татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн бөгөөд ингэж зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлснээр бизнес эрхлэгч болон харилцагчдаа урт хугацаатай, тогтвортой эх үүсвэрээр хангах, үйл ажиллагааг нь дэмжих боломж нэмэгдэх юм.

InvesCore

"ХӨВСГӨЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР САНАЛ ЗАРЛАЛАА

"Ард секюритиз УЦК" ХХК нь 2021 оны 4-р сарын 20-ны өдөр "Хөвсгөл" ХК-ийн нийт гаргасан хувьцааны 93.71 хувь /48,690 ширхэг/ буюу хяналтын багц эзэмшигч болсонтой холбоотойгоор Монгол Улсын Компанийн тухай хуулийн 57.1-т заасны дагуу тус компани нь "Хөвсгөл" ХК-ийн бусад нэгдмэл сонирхолгүй хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй энгийн хувьцааг худалдан авах санал гаргасан байна.

Санал болгож буй үнэ: 63.25 төгрөг

Санал гаргагчийн эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг: 48,690

Худалдан авах тоо ширхэг: 3,266 ширхэг

Хувьцааг худалдан авах саналын эхлэх хугацаа: 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдөр

Хувьцааг худалдан авах саналын дуусах хугацаа: 2021 оны 6 дугаар сарын 22-ны өдөр

Хувьцааны худалдан авах төлбөрийн хугацаа: 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдөр

Санал хүлээн авах хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард санхүүгийн нэгдлийн байрны 2 давхарт

Дэлгэрэнгүй мэдээллийг 77078181 утсаар авна уу.

ҮЙЛ ЯВДАЛ

"Е-МОНИЕ" ХК-ИЙН ХУВЬЦААГ ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР САНАЛ ЗАРЛАЛАА

"Ард менежмент УЦК" ХХК нь 2021 оны 2-р сарын 9-ний өдөр "Е-Моние" ХК-ийн нийт гаргасан хувьцааны 90.4 хувь /52,925 ширхэг/ буюу хяналтын багц эзэмшигч болсонтой холбоотойгоор Монгол Улсын Компанийн тухай хуулийн 57.1-т заасны дагуу тус компани нь "Е-Моние" ХК-ийн бусад нэгдмэл сонирхолгүй хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй энгийн хувьцааг худалдан авах санал гаргасан байна.

Санал болгож буй үнэ: 1,954 төгрөг

Санал гаргагчийн эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг: 52,925

Худалдан авах тоо ширхэг: 5,618 ширхэг

Хувьцааг худалдан авах саналын эхлэх хугацаа: 2021 оны 5 дугаар сарын 06-ний өдөр

Хувьцааг худалдан авах саналын дуусах хугацаа: 2021 оны 6 дугаар сарын 07-ны өдөр

Хувьцааны худалдан авах төлбөрийн хугацаа: 2021 оны 6 дугаар сарын 09-ны өдөр

Санал хүлээн авах хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард санхүүгийн нэгдлийн байрны 2 давхарт


Дэлгэрэнгүй мэдээллийг 77078080, 99043310 утсаар авна уу.

"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ТӨХК-ИЙН НИЙТ АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫН ХҮҮХДҮҮДИЙН ДУНД ЗАРЛАСАН ГАР

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан Хөрөнгийн зах зээл үүсч, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК байгуулагдсаны 30 жилийн ойн арга хэмжээний хүрээнд "Монголын Хөрөнгийн бирж" ТӨХК-ийн нийт ажилтан, албан хаагчдын хүүхдүүдийн дунд зохион байгуулагдсан гар зургийн уралдааны дүн гарлаа.

Сэдэв:

1. Миний аав, ээж-ийн ажлын газар /5-6 нас/ ангилалд Н.Ундрам
2. Миний мэдэх хөрөнгийн бирж /7-9 нас/ ангилалд М.Сийлэн
3. Хөрөнгийн зах зээл бидний нүдээр /10-12 нас/ ангилалд Б.Жаргалан нар тус тус түрүүлээ. Түрүүлсэн хүүхдүүд болон нийт оролцсон хүүхдүүддээ "Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийн мэндийг хүргэе.



Н.Ундрам (6 нас)



М.Сийлэн (8 нас)



Б.Жаргалан (12 нас)



2020 ОНЫ ЦЭВЭР АШГААС ТАРААГДАХ НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нийт хуваарилах ногдол ашиг / атөгрөг/	Нэгж хувьцаанд олгосон ашиг /төгрөг/	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр	Хуваарилах хэлбэр
1	EER	"Ариг гал" ХК	135,4 сая	38.93	2021.04.12	2021.6.30	ҮЦТХТ
2	TTL	"Таван толгой" ХК	28,1 тэрбум	535	Ээлжит хурлын бүртгэлийн өдөр	2021.04.21	ҮЦТХТ

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

№	Компаниудын нэрс	Цаг	Өдөр	Тайлбар
1	Монголын секюритиес	9:00	2021.05.26	Ээлжит хурал
2	Монголын хөгжил, үндэсний нэгдэл	15:00	2021.05.24	Ээлжит хурал
3	Хөсөг трейд	16:00	2021.05.21	Ээлжит

"ӨЛЗИЙ-ДУНДГОВЬ" ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ СЭРГЭЭЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн № 199 дүгээр тоот тогтоолоор "Өлзий-Дундговь" ХК-ийн үнэт цаасны арилжааг 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс сэргээхээр боллоо

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Сүхбаатарын талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747-2129



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN